

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар....

Улаанбаатар
хот

Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын улмаас эдийн засагт үүссэн хүндрэл, бэрхшээлийг бууруулах, бизнес эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг хадгалах зорилгоор авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын улмаас эдийн засагт үүссэн хүндрэл, бэрхшээлийг бууруулах, бизнес эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг хадгалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т, Монгол банк /Б.Лхагвасүрэн/-нд, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд даалгасугай:

1/жигжиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид болон иргэн, аж ахуй нэгжийн банк, банк бус санхүүгийн байгууллагаас авсан зээл, зээлийн хүүгийн төлөлтөд коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын улмаас учруулж байгаа хүндрэл, бэрхшээлийн талаар судалгаа гаргаж эрэмблэх;

2/жигжиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид болон иргэн, аж ахуй нэгжид банк, банк бус санхүүгийн байгууллагаас олгосон зээлийн хүүг 50-иас доошгүй хувиар бууруулах, зээл төлөлтийн хугацааг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд хойшлуулах асуудалтай холбоотой саналыг Улсын Их Хуралд танилцуулах;

3/зээлийн хүүг бууруулах болон зээл төлөх хугацааг хойшлуулсантай холбогдуулан банк, банк бус санхүүгийн байгууллагад үүсэх хүндрэлийг шийдэх, нэмэгдэл эх үүсвэрийг олох арга хэмжээг нэн даруй авах;

4/эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчид зориулсан түрээслээд өмчлөх хэлбэртэй орон сууцны өмчлөх болон түрээсийн төлбөрийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр түрээслэгчийн хүсэлтээр төлбөрийн хугацааг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хойшлуулах;

5/Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын улмаас эдийн засагт үүссэн хүндрэл, бэрхшээлийг бууруулахтай холбогдох хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Б.Жавхлан/, Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/, Улсын Их Хурлын Түр хороо /Б.Баттөмөр/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг